

Юньган агуйн уран баримлын тухай сурвалж, судалгааны тойм

Сарангэрэлийн Цолмон ✉

Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх урлагийн академи,
Улаанбаатар, Монгол Улс
✉ sehsne1228@163.com

Доржсүрэнгийн Уранчимэг

Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх урлагийн академи
Улаанбаатар, Монгол Улс

Ойдовын Хишигбат

Өвөр монголын Багшийн их сургууль
Хөх хот, БНХАУ

Хураангуй: Чулуун урлаг нь хүн төрөлхтний соёл, урлагийн түүхэнд гүн ул мөртэй, уран сайхны шийдлийн үнэ цэнээрээ онцгой байр суурь эзэлдэг дүрслэх урлагийн нэг төрөл билээ. Монголын нутагт Хүннү, Сяньби, Түрэг, Эзэнт гүрний үеийн урлагууд хөгжиж, соёлын үнэт өвийг бүтээсэн. Тэдгээрийн дотор Юньган агуй (UNESCO-ийн Дэлхийн өв)-н бурхдын чулуун баримал нь маш чухал судлагдахуун билээ. Энэхүү цогцолбор нь Сяньбийн үед хамрагдах бөгөөд 1500 гаруй жилийн түүхтэй, 51,000 гаруй ширхэг бурхдын хөрөг барималтай дэлхийн сонгодог дурсгалуудын нэг юм. Түүний нууцыг нээж, тухайн үеийн философи, шашны сүнслэг ертөнц, нийгмийн бүтцийг илтгэх гүн утгыг ойлгохын тулд судалгаа нь археологи, иконографи, иконологи гэх зэрэг олон салбарын шинжлэх ухааны аргыг нэгтгэн ашигладаг. Эдгээр арга зүйн дагуу хийсэн шинжлэх ухааны үнэлгээ нь энэхүү гайхамшигт бүтээл монголын соёлын алтан сан хөмрөгт байх ёстой хосгүй өвийн байр суурийг баталж, энэ нь зөвхөн уран дүрслэлийн арилшгүй үнэ цэн төдийгүй, дэлхийн соёлын өв, уран баримлын түүхэнд нэн ач холбогдолтой гэдгийг харуулж байна.

Түлхүүр үгс: Юньган агуй, уран баримал, сурвалж бичиг, судлагдсан байдал

Research Status of the Sculptural Art of the Yungang Grottoes

Tsolmon Sarangerel ✉

Academy of Fine Arts, Mongolia National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ sehsne1228@163.com

Uranchimeg Dorjsuren

Academy of Fine Arts, Mongolia National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Khishigbat Oidov

Inner Mongolia Normal University,
Hohhot, China

Abstract: Stone art is a distinct genre of visual art that holds a profound place in the cultural and artistic history of humanity, characterized by its unique artistic and aesthetic value. On the territory of Mongolia, the arts of the Xiongnu, Xianbei, Turkic, and Mongol Empire periods flourished, creating valuable cultural heritage. Among these, the Buddhist stone sculptures of the Yungang Grottoes (an UNESCO World Heritage Site) represent an exceptionally significant subject of study. This complex dates back to the Xianbei period, boasting a history of over 1,500 years and encompassing more than 51,000 Buddhist statues, making it one of the world's classical heritage sites. To uncover its mysteries and understand the profound meanings that reflect the philosophical and religious spirituality as well as the social structure of its time, research integrates scientific methods from multiple disciplines such as archaeology, iconography, and iconology. Scientific evaluations conducted based on these methodologies confirm that this magnificent work holds an irreplaceable position within Mongolia's cultural treasury. They demonstrate not only its enduring artistic value but also its profound significance in the history of global cultural heritage and monumental art.

Keywords: *Yungang Grottoes, sculptures, historical documents, research status*

Оршил

Хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд чулуун урлагийн бүтээлүүд эрт дээр үеэс эхлэн онцгой байр суурь эзэлж ирсэн. Эдгээр нь уламжлалт дүрслэх урлагийн унаган хэв шинжийг өнөөг хүртэл хадгалсан ховор төрөл юм. Ялангуяа Хуучин чулуун зэвсгийн үе, Шинэ чулуун зэвсгийн үед хүмүүс чулуугаар хийсэн уран бүтээлдээ амьдралын хэв маяг, шашин шүтлэг, өдөр тутмын үйл ажиллагаагаа тусгаж, урлагийн үзэл баримтлалаа илэрхийлсэн. Эдгээр дурсгал нь түүхэн соёлын гол төлөвшил, гоо зүйн мэдрэмжийг шинжлэх үнэтэй эх сурвалж болдог.

Монголын чулуун баримлын урлаг нь эртнээс уламжлалт тогтолцоотой хөгжиж, түүхэн явцдаа олон төрлийн дурсгалт бүтээлийг бий болгосон. Үүнд, Хүрэл зэвсгийн үеийн Буган чулуун хөшөө, МЭ IV-V зууны Юньган агуйн цогцолбор, XIII зууны хүн чулуун хөшөө зэрэг онцлог төлөөлөлтэй дурсгал хамаарна.

Тоба Вэй улсын үеийн Юньган агуйн уран баримлын цогцолбор нь дэлхийд алдартай чулуун урлагийн сонгодог өвийн нэг юм. Энэхүү дурсгалыг олон улсын судалгааны үр дүнд тулгуурлан, дүрслэх урлагийн онол, арга зүйн хүрээнд, шинжлэх ухааны аргаар системтэйгээр судлах нь Монголын дүрслэх урлагийн түүхийн судалгаанд шинэ чиглэл нээж, ялангуяа Юньган агуйн урлагийн Монголын урлагт гүйцэтгэсэн үүрэг, нөлөөг илүү гүнзгийрүүлэн тодруулах боломжийг олгоно.

Судалгааны арга зүй

Юньган агуйн уран баримлын судалгааны тоймд дараах аргуудыг ашигласан болно. Эх сурвалжийн задлан шинжлэх аргаар XII зуунаас эхлэн орчин үеийн эрдэм шинжилгээний сурвалж бичгүүдийг системтэй нэгтгэн шинжилсэн. Түүхэн судалгааны аргаар судалгааны үе шатыг гурван үе шат болгон хувааж, Умард Вэй улсын шашны сэргэн мандалтын нөлөөг онцлон тусгав. Археологийн аргаар хээрийн судалгаа хийж, иконографийн үүднээс судлан иконологийн зарчмаар утга тайлбарыг харгалзан, формаль стилистик зарчмаар Гандхар хэв маягаас орон нутагших үеийн урлагийн хувьсал, шашны бэлгэдлийг тодруулав. Харьцуулалтын аргаар дотоод хөгжлийн үе шат, гадаад урлагийн нөлөөллийг харьцуулан шинжлэхэд ашиглаж, салбар хоорондын судалгааны аргаар нүүдэлчдийн бүтээлч сэтгэлгээг судлан, задлан шинжилгээ, нэгтгэн дүгнэх зарчмаар судалгааны үр дүнг системтэй дүгнэв.

Судалгааны үр дүн

Түүхэн сурвалж: Юньган агуйн түүхийн тухай бичгийн дурсгалуудын дотор одоогоор мэдэгдэж буй хамгийн эртний эх сурвалж нь Цао Янь -ын “Алтан хөшөө” (1147 он) юм. Энэхүү түүхэн баримт нь “Алтан улсын баруун нийслэлийн Ү Жөу уулын чулуун агуйн хийдийг сэргээн засварласан хөшөө” гэдэг нэртэйгээр үлдсэн бөгөөд хожим нь “Алтан хөшөө” хэмээх товчилсон нэрээр алдаршжээ. Тус бичигт Умард Вэй улсын үеийн чулуун агуй, хийд, барилгын тухай дэлгэрэнгүй мэдээлэл агуулагдсан байдаг.

“Алтан хөшөө”-ний онцгой ач холбогдол нь Тан улсын Жэньгуаньгийн үеэс (627-649) Алтан улсын Хуантунгийн үе (1141-1149) хүртэлх түүхийн хагас мянган жилийн хоосон зайг нөхсөн чухал судалгааны материал юм. Энэхүү бичиг нь Юньган агуйн архитектур, уран баримлын хөгжил, засвар үйлчилгээний тухай үнэн зөв мэдээллийг өгч, судлаачдад үнэлж баршгүй эх сурвалж болжээ. Өнөөдрийн байдлаар “Алтан хөшөө” нь зөвхөн Юньган агуйн түүх биш, харин Тоба Вэйгийн нутагт буддын урлаг, соёл хэрхэн дэлгэрч хөгжсөн талаарх судалгаанд шинэ хуудсууд нээж байгаагаараа онцлог юм.

1665 онд Чин улсын эхэн үеийн эрдэмтэн Жу Изүнь Юньган агуйн түүхэн дэвсгэр, малтлагын шалтгаан болон урлагийн үнэ цэнийг аяллын тэмдэглэл хэлбэрээр тайлбарласан “Юньган чулуун Буддагийн тэмдэглэл” (Жүизүнь 1927) -ийг бичсэн байна.

Энэхүү хоёр баримт бичиг нь Юньган агуйн тухай XII зуунаас XX зууны эхэн үе хүртэлх хугацаанд бичигдсэн, одоогоор мэдэгдэж байгаа хамгийн чухал эх сурвалж юм.

Олон улсын түвшинд судлагдсан баримтууд: XX зууны эхэн үеэс эхлэн Сяньбичуудын өв уламжлал, урлаг, соёлын судалгаа эрчимтэй сэргэж, олон улсын түвшинд эрдэмтдийн сонирхлыг татаж эхэлсэн байна.

1902 онд японы барилгын ухааны доктор Ито Чүта энэхүү судалгааны эхлэлийг тавьжээ. Тэрээр Юньган агуйг санаандгүй тохиолдлоор илрүүлсний дараа тэр даруй “Юньганд хийсэн аяллын тэмдэглэл” болон “БНХАУ-ын Шаньши Юньган агуйн хийд” хэмээх бүтээлүүдээ хэвлүүлснээр Юньган агуйн судалгаа зөвхөн японы төдийгүй олон улсын судлаачдын сонирхлыг татжээ. Тухайлбал, 1907 онд францын алдарт хятад судлаач Эдуард Шавань гэрэл зурагчинтай хамтран БНХАУ-ын олон орон нутгуудад аялан үнэт гэрэл зурган материал цуглуулжээ. Шавань эдгээр материалаараа 1909 онд Парист Юньган, Лунмэнь агуйг багтаасан “БНХАУ-ын Умард бүс нутгийн археологийн зургийн цомог” (Шавань 1909) хэмээх хоёр боть бүтээлээ хэвлүүлсэн байна. Энэхүү бүтээл нь нийт 545 хуудастай бөгөөд Юньган агуйн анхны зургийн материалыг дэлхийд танилцуулсан түүхтэй. Энэхүү гэрэл зургийн бүтээлүүд нь дүрслэх урлагийн судалгаанд үнэтэй хувь нэмэр болж байна.

1919 онд БНХАУ-ын эрдэмтэн судлаач Чэнь Юань “Датунгийн Вужоу уулын чулуун агуйн хийдийн тэмдэглэл” болон “Юньган агуйн хийд орчуулсан судар ба Лю Шяаобяо” гэсэн эрдэм шинжилгээний өгүүллээ нийтэлжээ (ЧэньЮань 1980). Энэхүү судалгааны бүтээл нь БНХАУ-ын эрдэмтдийн Юньган агуйн тухай судлалын эхлэл нь болсон юм.

1920-оод оны үед шведийн алдарт урлаг судлаач Освальд Сирен (Osvald Sirén) БНХАУ-ын урлаг, барилгын судалгаанд анхаарч ажилласан. Тэрээр 1925 онд хэвлэгдсэн “V-XIV зууны БНХАУ-ын баримал урлаг”-т “энэтхэгийн буддын барималтай харьцуулахад БНХАУ-ын буддын баримал нь ерөнхийдөө илүү хүний дүртэй, өнгө чимэглэлтэй харагддаг. БНХАУ-ын уламжлалт хэлбэр, тэмдэг зүйнд шинэ урлагийн үнэ цэнийг нэвтрүүлснээр эдгээр баримлыг ойлгоход илүү хялбар, харин оюун санааны үнэ цэнээ бүрмөсөн хадгалсан гэж хэлж болно” (Сирен 2019, 7) гэж үзжээ. Энэхүү судалгааны бүтээлд Юньган агуйн урлагийн хэв маяг, түүхэн өнгө төрх, соёлын үнэ цэнийг нарийвчлан шинжилж, их хэмжээний гэрэл зургийг хавсаргасан байдаг. Хожим нь Лян Сычөн, Линь Хуйинь зэрэг БНХАУ-ын анхны барилгын судалгааны нийгэмлэгийн судлаачид түүний нөлөөлөлд 1930-аад оны үед Юньганд барилгын хэв маягийн талаарх анхны нарийвчилсан судалгааг хийж, 1933 онд “Юньган агуйд илэрхийлсэн Умард Вэй улсын барилга” өгүүлэл нийтлүүж БНХАУ-ын судалгааг цаашид хөгжүүлэв.

Ийнхүү олон судлаачдын судалгаа нь Юньган агуйн судалгааны үндэс суурийг тавьж, Сяньбичуудын өв соёлыг олон улсын судлаачдын анхаарлын төвд оруулсан гэж үзэж болно. Эдгээр ажил нь зөвхөн түүхэн баримт биш, харин урлаг, соёлын өвөрмөц үнэ цэнийг илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

XX зууны дунд үеийн судалгааг авч үзвэл, 1950-1956 оны хооронд Японы эрдэмтэн Тошио Нагахиро болон Мизүно Сэйчи нар Юньган агуйн урлаг, соёл, түүхтэй холбоотой анхны томоохон бүтээл болох 16 боть 32 хэсгээс бүрдсэн тайланг Токиод цувралаар хэвлүүлсэн явдал болно. Тэд 1930-1940-өөд оны хооронд Юньган агуйнд зургаан жилийн турш хээрийн судалгаа явуулж, зураг авалт, хэмжилт хийж, үр

дүнгээ “Юньган агуй -V зууны БНХАУ-ын умард бүс нутгийн буддын чулуун агуйн археологийн судалгааны тайлан” нэртэй бүтээл болгон эмхэтгэсэн байна. Энэхүү бүтээл нь Юньган агуйн урлаг, түүх, соёлын талаар гүнзгий ойлголт өгсөн юм.

Тошио Нагахиро болон Мизүно Сэйчи нар Юньган агуйн урлаг нь БНХАУ, барууны соёлын хоёр хэвийн шинж чанарыг илэрхийлдэг гэж үздэг. Эхний үеийн дүрслэл нь Гандхар, энэтхэг, Төв азийн урлагийн хэв маягт үндэслэсэн байхад, БНХАУ-ын уламжлалт урлаг нь амьтны сийлбэр, модон барилгын элементүүд болон нутаг орны хувиргалтаар аажмаар илэрдэг байна гэжээ. Тэд Юньган агуйн урлагийн хөгжилд гурван үе шат ялгажээ (Сэйчи 1956, 2). Үүнд, эхний үе: Тань Яогийн таван агуй, 16-20, 7-8. Хоёр дахь үе: 1-3, 5-6, 9-13. Гурав дахь үе: 4, 14, 15, 20-р агуйгаас баруунш юм. Агуйг дугаарлаж ангилсан ч энэ нь барууны Гандхар урлагийн хэв маягаас БНХАУ-ын нарийвчилсан гоо зүйн хөгжилд шилжих үйл явцыг тодорхой харуулдаг. Ялангуяа 7-8-р агуйн шилжилтийн шинж чанар нь буддын урлагийн хятад соёл руу хувирлын динамик замналд онцгой чухал ач холбогдолтой юм.

Тошио Нагахиро болон Мизүно Сэйчи нарын судалгаа нь Юньган агуйн урлагийн хөгжил, түүний соёлын утга учрыг ойлгоход чухал хувь нэмэр оруулсан бөгөөд энэхүү бүтээл нь өнөөг хүртэл урлагийн түүх, археологийн судлаачдын хувьд гол лавлах материал болсоор байна.

1947 онд БНХАУ-ын Бээжин их сургуулийн профессор, эрдэмтэн судлаач Сү Бай сургуулийнхаа номын сангаас Цао Яньгийн бичсэн “Алтан хөшөө” номыг олж уншсанаар тэрээр энэхүү баримтыг нарийвчлан судлах боломж бүрдэн судалж, 1956 онд “Алтан улсын баруун нийслэлийн Ү Жөү уулын чулуун агуйн хийдийг сэргээн засварласан хөшөөний тухай тайлбар” гэх эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн юм. Энэхүү судалгаа нь Юньган агуйг судлахад “Алтан хөшөө”-ний түүхэн чухал үнэ цэнийг бүрэн нотолж, цаашид үе шаттай судлах үндэс суурийг тавьсан гэж үзэж болно. Юньган агуй нь XII зууны Ляо болон Алтан улсын үед томоохон сэргээн засварлалт хийгдсэн боловч Чин улсын эхэн үеэс эхлэн орхигдсон түүхтэй. Иймээс энэхүү баримт нь зөвхөн түүхэн үнэ цэнээс гадна, Юньган агуйн сэргээн засварлалтын түүхийг ойлгоход чухал ач холбогдолтой юм.

Сү Бай Юньган агуйн соёлын болон урлагийн үнэт өв болох асуудлыг судлахдаа голчлон археологи, түүх болон цаг хугацааны ангилал, төрөл зүйлийн судалгааны ажлуудыг хийснээрээ Юньган агуйн судалгаанд шинэ хувьсгал авчирсан. 1956 оноос хойш тэрээр “Юньган агуйн үе шатны судалгаа”, “Алтан хөшөөний илрүүлэлт ба судалгаа”, “Пинчөнгийн хүчний төвлөрөл ба ‘Юньгангийн хэв маяг’-ийн бүрэлдэн хөгжсөн байдал” зэрэг олон чухал өгүүллүүдийг хэвлүүлж, эдгээр бүтээл нь “БНХАУ-ын Чулуун агуйн сүмийн судалгаа” номд орсон байна. Эдгээр судалгаа нь түүх судлал, археологийн үүднээс Юньган агуйн хөгжлийн үе шатыг тодорхойлж, шинэ үеийн судалгааны эхлэлийг тавьсан юм. Сү Бай Юньган агуйн хөгжлийг гурван үе шатад хувааж үзсэн (СүБай 1996, 76). Үүнд, эхний үе: 16-20-р агуйнууд эхний үеийн хэв маягийг төлөөлдөг. Хоёр дахь үе: 7-8, 9-10, 5-6, 1-2-р агуйнууд, 11-13-р агуйнууд, мөн 3-р агуйг багтаасан бөгөөд дунд үеийн хөгжил ба өөрчлөлтийг харуулдаг. Гурав дахь үе: 20-р агуйнаас баруун зүгт орших агуйнууд, 4, 14, 15-р агуй болон 11-р агуйгаас баруунтаа орших гаднах жижиг агуйнууд, 4-6-

р агуйн хоорондох дунд жижиг агуй, энэ нь сүүлийн үеийн хэв маягийг тусгадаг гэж үзжээ.

Японы эрдэмтэн Тошио Нагахиро нарын судлаачид эхэндээ Юньган агуйн 7, 8-р цогцолборыг “Тань Яо-ийн таван агуй” 16-20-р агуйн үеийн эхэн үе хэмээн ангилж, уг агуйнуудын баригдсан цаг үеийг Тань Яо-ийн таван агуйтай зэрэгцүүлсэн байна. Тэд агуйн хийц, баримлын хэв маягт Гандхар урлагийн элемент зэрэг гадаад нөлөөг хадгалсан онцлогийг голлон тулгуурлан, эхний үеийн агуйнуудтай холбоотой гэж үзжээ.

БНХАУ-ын эрдэмтэн Сү Бай “Алтан хөшөө”-г судлан, түүнийг Умард Вэй улсын түүхэн нөхцөлтэй холбон 7, 8-р агуйг Юньганы дунд үеийн эхний бүтээлд хамаарна гэж тодорхойлжээ. Тэрээр хос агуйн хийцийн анхны хэрэглээ нь буддын урлагийн хятаджуулалтын эхлэл болохыг онцолж, 7, 8-р агуйн бүтэц, дүрслэл нь Тань Яо-ийн таван агуйнаас ялгаатай боловч 9, 10-р хос агуйтай төстэйг тэмдэглэсэн байна.

1990 онд Тошио Нагахиро эцэст нь Сү Байн үе шатны ангиллыг хүлээн зөвшөөрсөн нь энэхүү академик маргаан Юньганы судалгааг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулснаас гадна БНХАУ-ын агуйн археологид бичиг баримт болон нотолгоог хослуулсан дэг журмыг тогтоосон юм.

АНУ-ын Калифорний Технологийн их сургуулийн Христос Христофору 1995 оны докторын диссертацидаа орчны инженерийн аргаар Юньган агуйн агаарын урсгал, тоосонцор наах үйл явцыг судалж, агуйн дотор, гадаадын температурын зөрүүгээр үүсдэг байгалийн агаарын эргэлт нь бохирдлыг тээвэрлэх гол механизм болохыг тогтоож, тоосонцор шүүх системээр 97% бохирдлыг үр дүнтэй саармагжуулж болохыг шинжлэх ухааны үндэслэлээр нотолсон (Christoforou 1995). Энэхүү судалгаа нь Юньган агуйн урьдчилан сэргийлэх хамгаалалтын судалгаанд шинжлэх ухааны арга зүйн хэрэглээний нэгэн эртний жишээг санал болгодог.

Сяньбичуудын чулуун агуйн урлаг нь буддын шашинтай салшгүй холбоотой. Умард Вэй улсын Вэньчөн хаан шашныг сэргээнээс хойш шүтлэг мөргөл, буддын урлаг, сүм хийдийг сэргээн байгуулах ажил харьцангуй идэвхжиж, соёл урлагийг сэргээн дэлгэрүүлжээ. Урлагийн түүхэн судалгааны талаар сүүлийн үед япон эрдэмтэн Хинако Ишимацу “Умард Вэй улсын буддын шашны дүрслэлийн түүхийн судалгаа” нь Умард Вэй улсын үеийн буддын шашны дүрсийн хэв маяг болон түүний хувьслыг судалж, буддын урлагийн тархалтын замнал, гоо зүйн онцлог болон бүс нутгуудын харилцан нөлөөллийг тодруулан буддын шашны урлагийн түүхэнд илүү нарийвчилсан судалгааг бий болгосон юм (Ишимацу 2012).

Жой Лиду И-ийн 2018 онд хэвлүүлсэн “Юньган: Урлаг, түүх, археологи, ёс суртахуун” ном нь Юньган агуйг нийгмийн урлагийн түүхийн үүднээс цогцоор нь судалсан барууны эрдэмтдийн анхны бүтээлд тооцогддог. Энэхүү судалгаа нь урлагийн түүхийн үзэл бодлыг баримтлан, уламжлалт Юньган судалгааны хэв маяг, он цагийн тодорхойлолт, дүрсийн таних зэрэг хэвшмэл хандлагыг эвдэж, гол асуултыг тавьсан. Агуйн сүм нь шашны орон зай болохынхоо хувьд ямар бодит үйл ажиллагаа явуулдаг байсан бэ. Зохиогч хоёрдугаар шатны агуйг, ялангуяа 12-р агуйг жишээ болгон, эдгээр нь зөвхөн бясалгал, тахилын газар төдийгүй “дуулалт”, “номлол” зэрэг хөгжим, үйл явдлын өгүүллэгтэй нийгмийн ёс суртахууны үйл

ажиллагаа явуулдаг байсан боломжтой гэдгийг нотолсон. Агуйн архитектурын хэлбэр, дүрсийн дараалал, баримт бичгийн эх сурвалжийг харилцан нотлох аргаар судалж энэхүү судалгаа нь Юньган агуйн сүм нь хараа, сонсгол, үйл ажиллагааг нэгтгэсэн динамик ариун орон зай бөгөөд урлагийн хэлбэр нь эцэст нь тодорхой шашин болон нийгмийн амьдралд үйлчилдэг болохыг илчилсэн юм (Лиду И 2018, 111).

Пакистаны Лакхорын Боловсролын их сургуулийн судлаач Чу Мен, доктор Мухаммад Захир нарын 2025 оны судалгаанд “Хаан хатан Буддад мөргөх” сэдвийг дэлгэрэнгүй авч үзсэн (Chu Meng 2025, 124-135). Энэхүү судалгааны гол ач холбогдол нь уг сэдэв нь зөвхөн урлагийн хэлбэрийн өөрчлөлт биш, харин төрийн төвт удирдлагын дор Кунзын сургаал, бумбын шашны ертөнцөд суурилсан үнэт зүйлсийг нэгтгэн, буддын шашны зан үйлийг ордны түвшнээс ард түмний өдөр тутмын амьдралд нэвтрүүлсэн цогц соёлын өөрчлөлтийн ажиллагаа гэдгийг онцлон тодруулсан явдал юм.

Монгол Улсад судлагдсан байдал: IV-V зууны үед Тоба Вэй улсын нийгэмд буддын шашны урлагийн нөлөө хүчтэй байсан нь шүтлэгийн зориулалттай олон тооны байгууламжаас ажиглагддаг. Үүнд “Монголын эртний түүх”-д “Умард Вэй улсын үед холбогдох бурхны шашны гайхамшигт дурсгалууд нь тухайн үеийн бурхны шашны дэлгэрэлтийн гэрч болон бидний үеийг хүртэл хадгалагдан иржээ” (Дэлгэржаргал 2017, 138) хэмээн Юньган агуйн талаар дурдсан байдаг.

Судалгааг газар зүйн хүрээнд авч үзвэл, Умард Вэй улсын нийслэл бөгөөд улс төр, соёлын төв нь Пинчөнд байсан. Иймд энэхүү судалгааны ажилд Юньган агуйн суурьшил болон түүний бурхан шашны агуулга бүхий баримлуудыг Умард Вэй улсын нийслэл Пинчөн хотыг төвлөрүүлэн судалсан байна. “Монголын нүүдэлчдийн дүрслэх урлаг”-т “...Датун хот өмнө нь буддын шашныг ихээр хөгжүүлж байсан нүүдэлчин гаралтай Тоба буюу Умард Вэй улсын нийслэл хот байв. Умард Вэй улсын үед байгуулагдсан буддын шашны байгууламжууд нь Хятан улсын үед ч Датунд үүргээ хэвээр үргэлжлүүлэн, сэргээн засварлах ажил ч эрчимтэй хийж байсан баримт байна. Мөн нэлээд олон тооны сүм хийд баригдаж байсан баримт байна. Шилдэг уран бүтээлчдийн бүтээсэн буддын уран баримлын урлагийн бүтээлүүд Гандхарын уран баримлын сургуулийн бүтээлүүдтэй эн зэрэгцэх хэмжээнд үнэлэгдэн байна” (Одпүрэв 2021, 41) гэж газар зүйн байршил болон шашны үнэт бүтээл болох талаас дурдсан байна.

Эдгээр судалгаа нь зөвхөн монголын түүх, соёлыг судлахад чухал ач холбогдолтой төдийгүй, буддын шашны урлагийн хөгжлийн талаарх шинэ мэдээлэл, дүгнэлтийг гаргана. Юньган агуйн баримлууд нь тухайн үеийн нийгэм, шашны хөгжлийн түвшнийг илтгэхээс гадна, урлагийн хэв маяг, технологийн дэвшлийг судлахад чухал материал болдог. Иймд эдгээр дурсгалыг нарийвчлан судлах нь монголын болон дорно дахины урлагийн түүхийг гүнзгийрүүлэн ойлгоход ихээхэн тус болох болно.

Хэлэлцүүлэг

Юньган агуйн судалгаанд урлагийн хэв маягийн орон нутагших байдлыг голлон авч үздэг. Үүнтэй зэрэгцээд соёлын нэгдлийн нарийн механизмыг илүү гүнзгийрүүлэн судлах нэгэн өнцөг бий болжээ. Энэхүү судалгааны чиглэл нь урлагийн гадаргаас дотоод орон зай, бүтэц, чимэглэлийн нарийн зүйлийг судалж, нүүдэлчдийн соёл иргэншлийн уламжлалт элементүүд агуйн бүтээн байгуулалтад хэрхэн нэвтэрснийг тодруулахыг зорьдог.

Эрдэмтэд агуйн орон зайн зохион байгуулалт, тахил үйлдэх замнал, чимэглэлийн загварыг тухайн цаг үеийн евроазийн тал нутгийн материаллаг соёлын дурсгалтай харьцуулж судалдаг. Гол асуулт нь агуйг бариулсан Сяньбийн удирдагчид болон урчууд буддын шашин, хятадын урлагийн хэлбэрийг хүлээн зөвшөөрөхдөө өөрсдийн соёлын мэдрэмж, илэрхийллийн аргыг хадгалсан эсэхийг авч үзсэн. Энэхүү судалгааны гол үнэ цэн нь соёлын нэгдлийг зөвхөн нэг талын шингээлт гэж үзэх хандлагыг эвдэж, харин өөр өөр соёлын элемент хэрхэн уян хатан хослон, шинэ утга илэрхийлэл бий болгох динамик үйл явцыг тайлбарлахад оршино. Энэ нь Юньган агуйг энгийн орон нутагшуулсан бүтээл биш, харин олон соёлын уян хатан хослол, шинэчлэлийн амьд талбар хэмээн ойлгоход чухал хувь нэмэр оруулж байна.

Дүгнэлт

Хүннү, Сяньби, Жужан, Түрэг, Хятан болон Эзэнт гүрний үеийн урлаг нь үе дамжин уламжлагдаж, шинэчлэгдсээр ирсэн баялаг түүхтэй. Иймээс монголын дүрслэх урлагийн түүхийн чухал хэсэг болох Юньган агуйн уран баримлын тухай сурвалж, судалгааны тоймыг дүгнэн үзвэл:

- Судалгааны тойм нь 1147-2025 он хүртэлх урт хугацааны судалгааны материалыг хамарснаараа шинэлэг.
- Судлаач эрдэмтдийн улс гүрний хувьд Япон, Франц, Швед, АНУ, Пакистан, БНХАУ, Монгол Улс зэрэг орнууд хамрагдаж байна.
- Судалгааны чиглэлийн хувьд архитектур, археологи, түүх, шашин зэрэг олон салбарт өргөн хүрээтэй хийгдсэн ч, дүрслэх урлаг, ялангуяа уран баримлын урлагийн онцлогийн талаар цогцоор нь судалсан нэгэн сэдэвт бүтээл харьцангуй хомс байна.
- Юньган агуй нь 1500 гаруй жилийн турш төр улсын нийслэл байсан газартаа сүндэрлэн оршиж, анхдагч хэлбэрээрээ хадгалагдсаар ирсэн төдийгүй монголын дүрслэх урлагийн түүхийн бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэж, бүх цогцоос нь судлан шинжлэх нь зүйтэй.
- Юньган агуйн уран баримал нь Сяньбичуудын соёлыг судлахад үнэтэй хувь нэмэр оруулах гайхамшигт дурсгалт газар бөгөөд түүний уран баримлын бүтээлүүдийг нарийвчлан судлах шаардлагатайг үндэс болгон энэ удаад судлагдсан байдлыг тодруулан гаргаж ирэхийг зорьсон юм.

Ашигласан материалын жагсаалт

Дэлгэржаргал, П. 2017. *Монголын эртний түүх-Сяньби*. Улаанбаатар: МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн.

Гадаад хэлээр:

Жой, Лиду И. 2018. *Юньган: Урлаг, түүх, археологи, ёс суртахуун*. Нью Йорк: Routledge.

Жу Изүнь. 1927. *Бао шу тин жи ·Юньган чулуун Буддагийн тэмдэглэл*. Бээжин: Арилжааны номын дэлгүүр хэвлэлийн газар.

Ишимацу, Хинако. 2012. *Умард Вэй улсын Буддын шашны дүрслэлийн түүхийн судалгаа*. Бээжин: Түүхийн дурсгалт хэвлэлийн хороо.

Одпүрэв, Г. 2021. *Монголын нүүдэлчдийн дүрслэх урлаг*. Улаанбаатар: Адмон принт ХХК.

Сирен, Освальд. 2019. *5-14-р зууны БНХАУ баримал урлаг*. Гуанжоу: Гуандун хэвлэлийн газар.

СүБай. 1996. *БНХАУ-ын Чулуун агуйн сүмийн судалгаа*. Бээжин: Соёлын Өвийн Хэвлэлийн Газар.

Сэйчи, Тошио Нагахиро, Мизүно. 1956. *Юньган агуй, 16-р боть*. Киото: Киото их сургуулийн Хүмүүнлэгийн шинжлэх ухааны судалгааны хүрээлэн.

Чэнь, Юань. 1980. *Чэнь Юаний эрдэм шинжилгээний өгүүллүүдийн цуглуулга-Нэгдүгээр цуглуулга*. Бээжин: Дундадын номын хэвлэлийн газар.

Шаван, Эдуард. 1909. *БНХАУ -ийн Умард бүс нутгийн археологийн зургийн цомог*. Парис.

Christoforou, Christos S. 1995. “БНХАУ-ын Юньган агуйд агаарын солилцоо, тоосонцор намдах процессыг хянах.” АНУ: Ph.D. diss., California Institute of Technology.

Chu, Meng, Zahir, Muhammad. 2025. “БНХАУ дахь буддын урлагийн орон нутгийн нөлөө: Вэй, Жин, Өмнөд, Хойд улсуудын үеийн “Хаан Хатан Буддад мөргөх” жишээн дээр.” *Хөгжил ба Нийгмийн Шинжлэх Ухааны Сэтгүүл* 6(1): 124–135. [https://doi.org/10.47205/jdss.2025\(6-1\)12](https://doi.org/10.47205/jdss.2025(6-1)12).